

## ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМЭР САНААТАЙ ТАВИХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЖ

### CRIMINAL LAW ON AN INTENTIONAL CRIME OF STEPPE AND WILD FIRE



**Б.Машбат.** ХСИС-ийн Онцгой байдлын сургуулийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхмийн дэд профессор, онцгой байдлын дэд хурандаа  
**Mashbat.B.** Adjunct professor of Firefighter training faculty, Emergency Management institute, Law Enforcement University, Lieutenant colonel

**Abstract:** The purpose of this report is to provide democratic, honor and publicity principle of legal policy and decrease the number of potential crimes for fire against environmental protection by identifying suspects of intentional crime of steppe and wild fire and strengthening a binding effect for guilty.

Хүн төрөлхтнийг байгалгүйгээр төсөөлөхийн аргагүй. Байгаль орчин нь бидний амьдрал, үйл ажиллагаатай шууд ба шууд бусаар хамааралтай байдаг. Шинэ технологийн тогтолцоог буй болгосон шинжлэх ухаан техникийн дэвшил заримдаа экологид гэм хор учруулж, хүн төрлөхтөний оршин тогтнох биологийн үндэст түүний нөлөөлөх аюулын хэмжээ өсөх хандлага ажиглагдаж байна.

Экологи гэдэг нь /oikos гэсэн грек гаралтай гэр, орон сууц, байрладаг газар, logos латиний судлал, сургааль гэсэн үгнээс гаралтай, Ургамал амьтан хоорондоо болон орчин тойронтойгоо хэрхэн харьцан амьдарч байдгийг/ судалдаг шинжлэх ухааныг экологи гэнэ.<sup>220</sup>

Ой хээрийн түймэр санаатай тавих гэмт хэрэг нь Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн “Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг” 23 дугаар бүлэгт хамаарагдана.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн нийгийн аюул нь байгалиар дамжин хүмүүст халдаж, тэдний оршин биологийн үндсийг устгах буюу чанарын хувьд дордуулахад оршино.

Төрлийн объект нь байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, хүн болон байгалийн бусад амьд эд эсийг хэвийг байлган экологийн эрх зүйн дэг журам, хүн амын аюулгүй байдлыг хангах эрх ашиг юм.

Шууд объект нь байгалийн тодорхой баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүн амын экологийн

аюулгүй байдлыг хангах эрх ашиг мөн. Жишээлбэл: Хууль бусаар ан агнах, гэмт хэргийн шууд объект нь ан амьтан, шувуу, загасыг хамгаалах, зүй зохистой ашиглах эрх ашиг юм.

Энэ гэмт хэргийн халдлагын зүйл нь хүний хөдөлмөрөөр бүтээгүй, байгаль өөрийнхөө жам ёсоор буй болгосон юмс байна.

Объектив тал нь ихэнх гэмт хэрэг нь хор уршигт гэмт буруугийн боломжгүй хэлбэрээр хандсан байна. Тэгэхдээ байгаль орчныг ашиглах, хүрээлэн буй орчныг хамгаалах журам зөрчихөд санаатай хандсан байна.

Экологийн эсрэг гэмт хэрэг гэдэг нь Монгол улсын экологийн аюулгүй байдал, экологийн талаар тогтоосон журам, хүний эрүүл мэнд болон орчин тойронд хор хөнөөл учруулахад чиглэгдсэн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

Ой хээрийн түймэр санаатай тавих гэмт хэргийн тухай ойлголтыг авч үзэхийн өмнө хэд хэдэн нэр томъёог тайлбарлах нь зүйтэй гэж үзэж байна.

“Гал түймэр” гэж хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн болон хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгалийн баялаг, нийгэмд хохирол учруулах шаталтыг хэлнэ.

Гал түймэр нь асар богино хугацаанд гамшигт үзэгдэл болон хувирдаг. “Гал түймрийн гамшиг” гэж объектын болон ой хээрийн гал түймэр өргөжин дэлгэрч олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, байгалийн баялаг эд хөрөнгө их хэмжээгээр сүйрэхэд хүргэх нөхцөл байдлыг ойлгодог гэж галын аюулгүй

<sup>220</sup> Советкий энциклопедический словарь. М. 1983. 1548 стр.

байдлын тухай хуульд заажээ.<sup>221</sup>

“Гал” гэдэг нь дөл ба дөлөөр дагалдсан дулаан ялгаруулалтаар тодорхойлогддог шаталтын явц.<sup>222</sup>

“Шатлага гэдэг нь бодис материалаас дулаан, энерги ялгаруулж хүрээлэн буй орчинтой жингийн солилцоо эрчимтэйгээр явагдах физик химийн урвал.”<sup>223</sup>

Шатлага явагдахад гурван нөхцөл зайлшгүй шаардлагатай.

1. Шатах бодис материал
2. Исэлдүүлэгч /агаарын найрлаган дахь хүчилтөрөгч/
3. Дулааны эх үүсвэр байдаг.<sup>224</sup>

Гал түймэр нь хүний идэвхитэй үйл ажиллагаанаас гадна байгалийн ямар нэг үзэгдлийн улмаас болж гарах тохиолдол байдаг. Үүнд: Аянга цахилгаан, салхи шуурга, олон жил дарагдсан нүүрс, болон малын бууцанд цас борооны ус шингэж дулаан үүсч улмаар халж гал түймэр үүсвэрлэн гардаг.

Ой нь төрөл бүрийн мод, бут сөөг, заг зэргээс бүрддэг цогц ойлголт бөгөөд дэлхийн ургамлын өвөрмөц тогтоц болно. Ой нь мод бусад ургамлын байршил, төрөл, бүтэц, гадаргуугийн байдлаас хамаарах бөгөөд түүний бүрдэл хэсгүүд нь зөвхөн өөр хоорондоо төдийгүй ургамал амьтны аймгийг холбож байгаль орчинд асар их нөлөө үзүүлдэг.<sup>225</sup>

Монгол улсын нутаг дэвсгэрийн 10 орчим хувийг ой эзэлдэг. Түүний 60.7% нь шинэс, 16% нь заг, 7.8% хус, 4% нарс, 4.2% нь бусад мод эзэлдэг.

“Ойн түймэр” гэж хүний хяналтаас гадуур ойн талбайд тархсан гал.<sup>226</sup> Ойн түймэр нь байгалийн баялаг болон ан амьтан араатан жигүүртэн, ой мод, ургамал мөн түүнчлэн хүний амь нас эрүүл мэндэд хөрөнгөд хэмжээлшгүй хохирол учруулдаг.

“Хээрийн түймэр” гэж тал хээрийн бүс нутгийн ургамалд түймэр гарч, шаталт хээрийн талбайгаар тархах түймэр.<sup>227</sup>

Энэ үед төрөл бүрийн өвс, дэрс, бут сөөг, зэгс гэх мэт ургамал шатахаас гадна тухайн нутаг дэвсгэрт амьдарч буй араатан жигүүртэн, мал амьтан, өвөлжөө бууц зэрэг шатдаг. Хээр талын өвс ургамал нь хуурайшилтай үед маш эрчимтэй шатдаг. Хүчтэй салхитай үед хээрийн түймрийн шугаман хурд 500-670 м/мин хүрнэ. Хээрийн түймрийн нэг онцлог нь олон зуун хавтгай дөрвөлжин км газар нутгийг хамардаг.

Ой хээрийн түймэр санаатай тавьсны улмаас бага бус буюу үлэмж хэмжээний хохирол учирсан нь энэ хуулийн 84, 153 дугаар зүйлд заасан гэмт хэргийн

шинжгүй бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<sup>228</sup>

Бүлгийн хамаарлын хувьд Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн “Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг” 23 дугаар бүлэгт багтана.

Энэ гэмт хэргийн иш татсан диспозецтэй. Өөрөөр хэлбэл энэ зүйл ангийн үндсэн бүрэлдэхүүнийг тогтооход Эрүүгийн хуулийн тусгай ангийн 84, 153 дугаар зүйл ихээхэн нөлөөлөхөөр тусгагджээ.

Сонгох санкцтай. Хорих, баривчлах гэсэн хоёр төрлийн ялыг сонгон хэрэглэхээр хууль тогтоож тусгасан байна. Хорих, баривчлах ялын зөвхөн дээд хэмжээг тусгажээ.

Энэ гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй. Өөрөөр хэлбэл 213 дугаар зүйлийн хоёр дахь хэсгийн гэмт хэргийн нэг онцлог нь уг гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэнд, амь биед хор аюул учирсан байхыг заавал шаардахгүй, зөвхөн гэм буруутай этгээдийн үйлдлээр гал тавьсан буюу гал тавих бэлтгэл хийснээр уг гэмт хэргийг төгс үйлдсэнд тооцогдоно.

Ой мод болон түүний баялагт хор хохирол учруулах зорилгоор санаатайгаар галын эх үүсвэрийг ашиглан гал тавьж байгаа идэвхитэй үйлдлийг галдан шатаах гэнэ.

Ерөнхий объект нь Монгол улсын тусгаар тогтнол бүрэн эрхт болон үндэсний аюулгүй байдал, хүний амь бие эрүүл мэн, түүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин түүнчлэн эрх зүйн журам юм.

Уг гэмт хэргийн үндсэн объект нь: Ой болон бусад төрлийн ургамал экологийн аюулгүй байдлыг зохицуулагч нийгмийн харилцаа юм.<sup>229</sup> нэмэлт объект нь улс олон нийтийн байгууллага, иргэдийн эд хөрөнгийг хамгаалах талаар үүссэн нийгмийн харилцаа гэсэн давхар объектойд. Мөн түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд энэ гэмт хэргийн нэмэлт объект болно.

Энэ гэмт хэргийн халдлагын зүйл нь төрөл бүрийн ойн фондод багтах ургамал, /ой мод, бэлчээр/ ан амьтан, улс, ард иргэдийн эд хөрөнгө байна. Мөн гэмт халдлагад өртөн хохирогч нь хүн байна.

Ой хээрийн түймэр тавих гэмт хэргийн объектив тал нь ой хээрийн түймэр тавьсан нь эрүүгийн хуулийн хүчин чадлыг сулруулах зорилгоор галдан шатаах 153 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт зааснаар бусдын эд хөрөнгийг гэмт хэргийн шинжгүй ой хээрийн түймэр тавьсан идэвхитэй үйлдлээр илэрнэ. Түймрийг чүдэнз, шатах шингэн, асаагуур, гал болон цогтой эд зүйлээр, мөн түүнчлэн галт сум, шилэн линз, оч гаргагч төрөл бүрийн техник хэрэгсэлээр тавьдаг.

Ой хээрийн түймэр санаатай тавих гэмт хэргийн субъектив тал нь гэмт этгээдийн гэм буруугийн

<sup>221</sup> Галын аюулгүй байдлын тухай хууль. 1999.

<sup>222</sup> Гамшигийн нэр томъёны тайлбар толь. УБ. 2012. 55 тал

<sup>223</sup> Гамшигийн нэр томъёны тайлбар толь. УБ. 2012. 84 тал.

<sup>224</sup> А.А.Симонов.Физико-химические основы развития и тушения пожаров. М.1980

<sup>225</sup> Т.Сэнгэдорж “Экологийн эрх зүй” УБ хот 1997. 105-р тал

<sup>226</sup> Гамшигийн нэр томъёны тайлбар толь. УБ. 2012. 74-р тал

<sup>227</sup> Гамшигийн нэр томъёны тайлбар толь. УБ. 2012. 82-р тал

<sup>228</sup> Эрүүгийн хууль.УБ. 2002.

<sup>229</sup> Н.И.Петров. Уголовная права. Особенная часть. М. 2000. 343 стр.

шууд ба шууд бус санаатайн аль нэг хэлбэрээр илэрч болно. Өөрөөр хэлбэл тухайн этгээд өөрийн үйлдлийн улмаас болж ой хээрийн түймэр гарч хохирол учруулна гэдгийг мэдэж байсан боловч түүндээ зориуд хүргэсэн идэвхитэй үйлдэл байдаг. Сэдэлт нь бусдын өмчийг устгах буюу төрийн эсрэг чиглэсэн байж болохгүй. Өөр бусад сэдэлтэй байж болно. Тухайлбал: Ой модыг санаатайгаар шатаагаад дараа нь модыг нь ашиглах, эвэр түүх ажилаа хөнгөвчилөх үүднээс галдан шатаах зэрэг болно.

Зорилго нь сэдэлтийн мөн адил бусдын өмчид хохирол учруулах, төрийн эсрэг дайснагасан үйл ажиллагаа явуулах гэсэн зорилгогүй байдаг.

Харин энэ гэмт хэргийн субъектив талын онцлогийг тогтооход төрийн эсрэг хорлон сүйтгэх ажиллагаа явуулах (Эрүүгийн хуулийн 84-р зүйл), бусдын өмч хөрөнгийг санаатай устгах, гэмтээх (Эрүүгийн хуулийн 153-р зүйл) хэргүүдээс эрс ялгаатайг ямагт анхааран зөв зүйлчлэх нь чухал.<sup>230</sup>

Хэрэв Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бууруулах, мөн Монгол улсын хүчин чадлыг сулруулах зорилгоор ой хээрийн түймэр санаатай тавьсан бол 213 дугаар зүйл ангиар биш 84-р зүйл ангиар зүйлчлэгдэнэ. Гэм буруутай этгээдийн ой модыг шатаах гэсэн санаатай үйлдлийн улмаас түймэр гарч түүнээс улбаалаад монгол улсын эдийн засгийн хүч чадал суларсан тохиолдолд төрийн эсрэг гэмт хэргээр зүйлчлэхгүй. Учир нь тухайн этгээд өөрийн үйлдлээрээ төрийн эсрэг чиглэсэн ямар нэг зорилго сэдэлт агуулаагүй байдгаараа онцлогтой.

Бусдын өмчийг устгах зорилгоор ой хээрийн түймэр санаатай тавьсан бол /тухайлбал: бусдын өвөлжөө бууц зэргийг устгах зорилгоор/ бусдыг өмчийг санаатай устгасан 153, ой хээрийн түймэр санаатай тавьсан 213.2 зүйл ангиар давхар зүйлчилнэ.

Бусдыг алах зорилгоор ой хээрийн түймэр тавьсан бол бусдыг санаатай алах 91 дүгээр зүйлийн зохих хэсэг, 185-р зүйл ангиар давхар зүйлчилнэ. Өөрөөр хэлбэл дээрхи гэмт үйлдлээ хэрэгжүүлэх гол зэвсэг нь гал түймэр байдаг.

Тариалангийн талбайд гарсан түймрийг хээрийн түймэрт багтаан ойлгодог.<sup>231</sup> боловч тариалангийн талбайд тарьж ургуулж буй тариа, төмс хүнсний ногоог нь хүний хөдөлмөрөөр бүтэж байгаа зүйл учир тариалангийн талбайг санаатай шатаах үйлдэл нь бусдын өмчийг устгах 153-р зүйл ангиар зүйлчилнэ.

Гэм буруутай этгээд ой хээрийн түймэр тавьсан үйлдлийн улмаас болж бусдын амь нас эрүүл мэнд хохирол, эд хөрөнгө устаж сүйтгэхийг мэдэх бололцоогүй хүсээгүй байдаг.

Энэ хэргийг үйлдсэн этгээд, гэмт үйлдлийн эцэст ой, хээр, бэлчээр нь түймрийн аюулд сүйдэж болно

гэдгийг урьдчилан мэдэж, санаатайгаар хүсэж, зориуд бий болгосон байдаг тул гэм буруугийн сэдэлт, зорилго нь ой хээрийн баялгаас өөр зүйлд чиглэж халдаагүй байдаг.

Субъект: 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай Монгол улсын, гадаадын иргэн, харъяалалгүй этгээд байна. Дипломат халдашгүй дархан эрхтэй хүмүүс энэ гэмт хэргийн субъект болохгүй.

Ой хээрийн түймэр санаатай тавих гэмт хэргийн бүрэлдэхүүнийг зөв тодорхойлж гэм буруутай субъектэд хүлээлгэх хариуцлагыг чангатгаснаар "Байгаль хамгаалах журмын эсрэг" нуугдмал гэмт хэргийн тоог бууруулах, эрүүгийн бодлогын ардчилсан шудрага, ил тод байх зарчмыг хангахад чухал ач холбогдолтой гэж дүгнэж байна.

### Ном зүй:

1. Советкий энциклопедический словарь. М. 1983. 1548 стр.
2. Галын аюулгүй байдлын тухай" хууль. 1999.
3. Гамшигийн нэр томъёны тайлбар толь. УБ. 2012.
4. Монгол Улсын Эрүүгийн хууль.
5. Н.И.Петров. Уголовная права. Особенная часть. М. 2000. 343 стр.
6. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ. 1989.
7. А.А.Симонов. Физико-химические основы развития и тушения пожаров. М.1980.
8. Т.Сэнгэдорж "Экологийн эрх зүй" УБ хот 1997
9. И.Ф.Кимстач, П.П.Девлишев, Н.М.Евтюшкин. Пожарная тактика. М. 1986.

<sup>230</sup> БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ. 1989. 22 дугаар тал.

<sup>231</sup> И.Ф.Кимстач, П.П.Девлишев, Н.М.Евтюшкин. Пожарная тактика. М. 1986.